



ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН  
ГАЗАР

# ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## АУДИТЫН ТАЙЛАНГААС





# ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зааснаар төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс **2 жил** тутам батлан хэрэгжүүлсэн байна.

## Монгол Улсын нийт хүн амын тоо 2021 онд




**15-18** насны **177.3** мянган  
**19-65** насны **2,002.6** мянган иргэн байна.

Монгол Улсын нийт болон **15**-аас дээш насны хөдөлмөр эрхэлж буй хүн амын тооны харьцаа

Нийт хүн ам ▲

15-с дээш насны хөдөлмөр эрхэлж буй иргэн ○

Эх сурвалж: 1212.mn




Ажилгүйдлийн түвшнийг хүйсийн ангиллаар харьцуулсан үзүүлэлт /хувиар/

Эмэгтэй ▲

Эрэгтэй ▲

Нийт ○



Хөдөлмөр эрхлэлтийн салбарт хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийг хэмжих, үнэлгээ, үр нөлөөг тооцох хяналтын нэгдсэн тогтолцоо хангалтгүй байна.



# 1

## ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРГИЙН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАГДААГҮЙ БАЙНА.

Бодлогын баримт бичгүүдэд тусгасан "ажилгүйдлийн түвшин"-ий хүрэх түвшин

Баримт бичиг	Ажилгүйдлийн түвшин		
	2015-2016 /суурь түвшин/	2020	2025
Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	-	6.0	4.0
Алсын хараа-2050	-	8.6 /2018 он/	7.8
Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	7.0	6.5	7.8
Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	-	9.5 /2021 он/	8 /2024 он/
Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	7.5	5.6	5.0
Төсвийн тухай хууль	7.1	7.8	-
Тухайн жилийн статистик мэдээ	10	7.0	-

МСҮТ төгсөгчдийн ажлын байртай болсон хувь, хүрэх түвшинг харилцан адилгүй тусган баталсан


Бодлогын баримт бичиг	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь		
	2019	2021 /хүрэх түвшин/	2025 /хүрэх түвшин/
"Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"	65	70	-
Алсын хараа-2050	76.5	-	90
Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /2020-2025/	76.5	-	90
Монгол Улсын төсвийн тухай хуулийн 1-р хавсралт	65.5	67.5	-
ХНХЯ-ны статистик мэдээ	58.1	51.5	-

ХНХЯ нь төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдүгээр үе шатны төлөвлөгөөг батлуулаагүй, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг тооцоо судалгаанд үндэслэн төсөвлөөгүй байна.



# ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсөв, гүйцэтгэл /тэр.төг/



2018 оны гүйцэтгэл

2018 онд нийт **6** хөтөлбөрийн санхүүжилт **65.3** тэрбум төгрөг зарцуулсан төсөв **77.8%** **50.8** тэрбум төгрөг төсвийн үлдэгдэл **14.5** тэрбум төгрөг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг 2019 онд **94.5** тэрбум төгрөг, 2020 онд **170.2** тэрбум төгрөг, 2021 онд **179.3** тэрбум төгрөг болгон өсгөж баталсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээ

2016-2021 онд **532,457** иргэн хамруулж **373,789.9** сая төгрөгийг хуваарилсан

Нэг хүнд зарцуулсан хөрөнгө 2016-2019 онд **0.5-1.4** сая төгрөг болж өссөн бол


Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020-2021 онд **0.2** сая төгрөг болж буурсан.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хуваарилсан төсөв /2016-2021/

▲ Нийт зарцуулсан хөрөнгө /тэр.төг/

○ Нэг хүнд зарцуулсан хөрөнгө /сая.төг/

Эх сурвалж: www.1212.mn





## 2

### ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖИЛГҮЙДЛИЙГ БУУРУУЛАХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР НӨЛӨӨГ ТООЦОЖ, ҮНЭЛЭЭГҮЙ, ҮР ДҮН ТОДОРХОЙГҮЙ БАЙНА

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2016-2021 онд




**722,687**  
хүнийг хамруулж



**5,599.5** сая  
төгрөг зарцуулсан

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний 2016-2021 оны хэрэгжилт

Төсөв /сая. төг/ ▲  
Гүйцэтгэл /сая. төг/ ▲  
Хамрагдсан хүн /мян/ ○



Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд **491,059** хүнийг хамруулж **3,567.4** сая төгрөг

Ажилд зуучлах үйлчилгээнд **231,628** хүнийг хамруулж **2,031.8** сая төгрөг зарцуулсан



Үйлчилгээнд хамрагдсан нийт иргэнээс хэдэн хүн ажлын байртай болсон, сургалт, хөтөлбөр ямар үр дүнд хүрсэн, цаашид хэрхэн сайжруулж, боловсронгуй болгох талаар судалгаа, тооцоо, тайлан мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гаргаагүй тул уг арга хэмжээний бодит үр нөлөөг дүгнэх боломжгүй байна.

Ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэд нь байнгын болон түр ажлын байраар хангагдаж байна. Эдгээр иргэнийг мөшгөх судалгаанд хамруулахгүй байгаатай холбоотой энэ үйлчилгээний үр нөлөөг дүгнэх боломжгүй байна.

Ажилд зуучлах үйлчилгээг "Хөдөлмөрийн бирж"-ээр дамжуулан гүйцэтгэж, 2017-2021 онд улсын төсвөөс үйл ажиллагааны зардалд 791.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн хэдий ч үр нөлөөг тооцох боломжгүй, бий болсон байнгын ажлын байрны тоо хэмжээ тодорхойгүй байна.



# ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2016-2021 онд хэрэгжсэн хөтөлбөрүүдийн жагсаалт

Төсөл, хөтөлбөрийн нэр	Хэрэгжсэн он	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	Хамрагдсан хүний тоо
Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	2016	11,407.7	11,923
Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	2016	2,768.6	19,587
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2016-2021	51,816.8	150,925
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2016-2021	12,473.5	49,028
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2016-2021	22,625.2	28,154
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2016-2021	25,383.0	25,091
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	2016-2021	6,531.9	9,588
Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	2016-2021	5,216.5	39,528
<b>Дүн</b>		<b>138,223.2</b>	<b>333,824</b>



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарим орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, хөрөнгийн зарцуулалтын ч үр нөлөөг тооцоогүй, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөд тавих хяналт сул байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2016-2021 он /сая.төг/

	2016	2017	2018	2019	2020	2021
Төлөвлөгөө		400.0	400.0	1,000.0	1,300.0	1,300.0
Гүйцэтгэл	393.2	1,012.2	1,128.0	3,683.0	8,325.1	10,447.2
Төлөвлөгөөнөөс давсан орлого		612.2	728.0	2,683.0	7,025.1	9,147.2




Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарим орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг хуульд заасан дараах 9 эх үүсвэрээс бүрдүүлэхээр байна.

Үүнд:

- Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү;
- Гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр;
- Гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл;
- Гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх
- Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө;
- бусад эх үүсвэр.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын дийлэнх хэсгийг гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр эзэлж байна.

Эх сурвалж: ХХҮЕГ



# ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын гүйцэтгэл /2016-2021 он/ сая төгрөг

Орлогын төрөл	2016	2017	2018	2019	2020	2021
Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого	30,812.8	29,704.5	38,615.5	54,348.7	26,266.4	40,707.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрөөс орох орлого	393.2	1,012.2	1,128.0	3,683.0	8,325.1	10,447.2
Улсын төсөв			3,850.0	9,100.0	20,330.2	
Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж					7,415.0	1,217.2
Жижиг зээлийн эргэн төлөлт		17,000.0	4,350.0			15,900.0
Жижиг зээлийн хүү, алданги		187.3	156.6	67.2	256.9	340.5
Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	1,570.4	3,691.3	7,275.2			12,148.3
Санхүүжилтийн буцаалт						8,169.3
Бусад	264.1	12.1	167.4	29.6	14.1	7.7
Өмнөх оны үлдэгдэл			39,244.0	44,113.3	93,550.8	93,114.6
<b>ДҮН</b>	<b>33,040.5</b>	<b>51,607.4</b>	<b>94,786.7</b>	<b>111,341.8</b>	<b>156,158.5</b>	<b>182,052.1</b>

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2021 оны орлогын үйцэтгэлийг бүхэлд нь авч үзвэл


Өмнөх оны үлдэгдэл ▲

Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого ▲


Улсын төсөв ▲

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр ▲

Бусад орлого ▲



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын төлөвлөгөө 2017-2021 онд 13.3-92.2 хувиар давж биелсэн бөгөөд сангийн орлого байнга өссөн байна.



Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийг 3.5 тэрбум төгрөгөөр бүтээлгэсэн ашиглалтын шаардлага бүрэн хангахгүйгээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг давхардуулан авч байсан зөрчил илэрлээ.




# ТӨРӨЭС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН




Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих үндэсний зөвлөлөөс МБСДС-ийн тухайн жилийн орлого, зарлагын төсвийг батлаагүй, хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

МБСДС-ийн нийт зардал, суралцагчдад олгосон тэтгэлгийн хэмжээ /2016-2021/

Нийт зарлага ▲  
Тэтгэлэг ▲



Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад хичээлийн жилд сар бүр олгох тэтгэлгийн хэмжээ



Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллежид суралцагчдад тэтгэлэг олгох журмыг тухай бүр шинэчлэн баталсан байна.



Төслийн хэрэгжүүлэх



18-34 насны 2389 залуус

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ



14 хоног  
вакумжуулсан сургалт

ОРОЛЦОО

ЗАЛУУЧУУДЫГ ХӨДӨЛМӨРТ  
БЭЛТГЭХ ТӨСӨЛ



0.5-1.0 сая төгрөгийн  
тэтгэлэг олгосон

I үе шат

2021 он



7 хоног  
үйлдвэрлэлийн дадлагад

2021-2024 он

Нэгдүгээр үе шатны үр дүн

5000 залуусыг хамруулж 70% ажлын байртай болгоно гэж зорьсон 2389 иргэн хамрагдаж

2021 оны 12-р сарын 31-ний байдлаар

Байнгын ажлын байртай болсон иргэний 144 нь 1-3 сар . 291 нь 3-6 сар НДШ төлсөн




# ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН


Цар тахлын үед ажлын байрыг хадгалах, ААН-ийг дэмжих зорилгоор олон төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн нь цаг үеэ олсон үр дүнтэй ажил болсон байна.

## Нийгмийн даатгалын тайлан

Ажил олгогч үйл ажиллагаагаа зогсоосон



НДШ төлөгч байгууллагаар бүртгүүлсэн



Албан журмын даатгуулагчийн тооны судалгаанаас харахад даатгалд хамрагдсан иргэд /**мянга**/



## давхардалгүйгээр

2019 онд **825.2**

2020 онд **826.1**

2021 онд **862.1**

болж өссөн **ЭЭРЭГ** үр дүнтэй байна

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн баталсан хөтөлбөрүүдийн хүрээнд



2016 оноос хойш нийт **4,768** Иргэн, ААНБ

Нийт олгосон эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг **19,117.9** сая төгрөг

төлөлт хийгдсэн **6,425.8** сая төгрөг

хугацаа хэтэрсэн, гэрээний хугацаа дууссан үлдэгдэл **12,747.1** сая төгрөг



## ■ ДҮГНЭЛТ



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолд заасны дагуу 2016-2020 онд бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөгүй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна.



Бодлогын баримт бичгийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг мөрдөөгүй, хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарим шалгуур үзүүлэлтийг урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт харилцан уялдаагүй тусгасан байна.



Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлсэн хэдий ч бодлогын баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнээ хангаагүй, ажилгүйдлийн түвшин зорилтот түвшинд хүрээгүй, ахиц гараагүй байна.



Хөдөлмөр эрхлэлт хариуцсан төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг харилцан уялдаагүй, төсөл, хөтөлбөр боловсруулахад олон нийтийн оролцоог хангаагүй, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитой судалгаанд үндэслэн тооцоолоогүй, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын бодлогын хэрэгжилтийг хэмжих, тогтоосон хугацаанд журмын дагуу тайлагнаж, үнэлэн, үр нөлөөг тооцсоны үндсэн дээр цаашид боловсронгуй болгож сайжруулах нэгдсэн тогтолцоогүй байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг бодит хэрэгцээ шаардлага, санхүүгийн тооцоололд үндэслэхгүйгээр төлөвлөж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг хуульд заасан эх үүсвэрүүдээс бүрэн төвлөрүүлээгүй байна.



Төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, мөрөөр тавих хяналт сул, эргэн төлөлт хангалтгүй, хугацаа хэтэрсэн авлагын дүн жилээс жилд өсөж 12.7 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт муу байна.



Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн, үр нөлөөг тооцож үнэлээгүй, байнгын ажлын байраар хангагдсан хүний тоо тодорхойгүй байна.



Heds.explorer.net цахим системд санхүүгийн дэмжлэг авсан этгээдийн регистрийн дугаар давхардсан, 643 гэрээний мэдээлэлд нэг ижил утасны дугаар 2-55 удаа бичигдсэн байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн салбарын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаа хангалтгүй, системийн ажиллагаа бүрэн бус байна.

